



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын өөртөө засах орны хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын 10 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах кабель шугамын барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 129,300,000.00 (нэг зуун хорин есөн сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001933



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
АББ... дугаар тогтоолын хавсралт

"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн		Ашиглалт ад орсон он	Улсын комиссын акт дугаар	Хэм жих нэгж	Тоо	Бүгд	
		Улсын нэр	он					Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/
1	0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	Хятад	2013	2017	01//2018	км	1	26,800,000.00	26,800,000.00
2	Тоолуур нэгтгэсэн щит	Хятад	2013	2017	01//2018	ш	12	350,000.00	4,200,000.00
3	10/0.4 кВ 125 кВа трансформатор	Хятад	2013	2017	01//2018	ш	1	13,100,000.00	13,100,000.00
4	10/0.4 кВ 80 кВа трансформатор	Хятад	2013	2017	01//2018	ш	1	9,300,000.00	9,300,000.00
5	10 кВ-ын 4 км цахилгаан дамжуулах агаарын шугам	Хятад	2013	2017	01//2018	км	4.6	16,500,000.00	75,900,000.00
	Нийт үнэ						19.6	66,050,000.00 (жаран зургаан сая тавин мянган)	129,300,000.00 (нэг зуун хорин есөн сая гурван зуун мянган)